

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР
ТАНАА

2020.03.13 № 06/861
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Санхүүгийн тайлагналын үйл ажиллагааны циклд баримт эргэлтийн төлөвлөгөөг боловсруулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, НӨАТ төлөгч компаниас худалдан авах зарчмыг баримталж ажиллах, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд явуулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 25-аас 2020 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Б энд С аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хэрэглэгчийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалттай хангах
- Эрчим хүчний тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа
- Даралтат сав шугам хоолойг ашиглах
- Засвар үйлчилгээ хийх түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болно гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.
- ЭХЗХ-ны 2019 оны 286 дугаар тогтоол
- ЭХЗХ-ны 2019 оны 121 дүгээр тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив ХХК-ийн Даймонд программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,258.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 32.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 48.9 сая төгрөгөөр тооцсон нь суурь үзүүлэлтийн дүнг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,239.4 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,112.2	767.2	(345.0)
Авлага	2,433.3	3,323.9	890.6
Урьдчилгаа	795.0	797.5	2.5
Бараа материал	2,492.1	3,248.7	756.6
Үндсэн хөрөнгө	80,694.1	85,628.8	4,934.7
Нийт хөрөнгө	87,526.7	93,766.1	6,239.4
Өр төлбөр	1,753.8	7,203.2	5,449.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	85,772.9	86,562.9	790.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	87,526.7	93,766.1	6,239.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас авах цахилгаан эрчим хүчний авлага өссөнөөс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд дулаан эрчим хүчний авлага 127.2 сая, цахилгаан эрчим хүчний авлага 3,168.8 сая, хувь хүмүүсээс авах авлага 5.7 сая, байгууллагаас авах авлага 16.6 сая, татвар НДШ-ийн авлага 5.6 сая нийт 3,323.9 сая төгрөгийн авлага байна.

Тус компани нь цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлээд Төвийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлдэг ба төлбөрийг цахилгаан түгээх компаниуд цуглуулж, Диспетчерийн үндэсний төвийн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд хийж хуваарилдаг тул ЭДЦС ТӨХК-с хамааралгүйгээр авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь нүүрсний суурь үнэ 4000 төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд нүүрс 599.2 сая, үндсэн сэлбэг 87.4 сая, шатахуун, шингэн түлш 49.5 сая, химийн материал 39.5 сая, бусад хангамжийн материал 21.9 сая нийт 797.5 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнсэн сан №2-ыг хоослох ажил 6.0 сая төгрөгийн ажлыг орлогод авч, батлагдсан

төлөвлөгөөний дагуу хийгдсэн их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар 3,876.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2019 оны 398 дугаар тогтоолоор Хөвсгөл Дулааны станцад 119.0 сая төгрөгийн автомашиныг үнэ төлбөргүй шилжүүлсэн балансаас балансанд шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2019 оны 288 дугаар тогтоол, 2019 оны А-2/2526 тоот албан бичгийн дагуу 104.1 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, тайлант жилийн элэгдлийн зардал 5,011.3 сая төгрөгөөр байгуулсан дүнгээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь батлагдсан төлөвлөгөөний дагуу их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтаар программ ханамж 17.1 сая, Бодит нүүрсний жинг тооцох аргачлалын ном /оюуны өмч/ 22.7 сая, РХА-ийг тоон төхөөрөмжөөр шинэчлэх аргачлалын ном /оюуны өмч/ 20.0 сая, мөтөр замын хэвгийн зураг /оюуны өмч/ 10.0 сая нийт 69.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 6,040.0 сая төгрөгийн ажлыг ЭХЗХ-ны 2016 оны 53 дугаар тогтоолоор баталсан Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журмын 3.10-ын дагуу НББОУС-ын 20.12 заалтыг баримтлан орлогын аргаар бүртгэсэн нь урьдчилж орсон орлогыг нэмэгдүүлсэн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны 27 дугаар тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн зорилтот түвшнийг баталсан баталсан байна. Тайлант онд 38,112.0 сая төгрөгийн орлого, 40,510.8 сая төгрөгийн зардалтай ажиллаж, 2,398.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлагджээ.

Тайлант онд 38,112.0 сая төгрөгийн орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 40,723.0 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөг 2,611.0 сая төгрөгөөр буюу 106.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Цахилгаан эрчим хүчний орлого 2,664.5 сая төгрөгөөр давсан нь ЭХЗХ-ны 2019 оны 286 дугаар тогтоолоор тус компанийн ДҮТ ХХК-д худалдах цахилгааны үнийн тарифыг шинэчлэн тогтоосон, төлөвлөснөөс 4.3 сая кВтц цахилгаан эрчим хүч илүү түгээсэн зэргээс шалтгаалжээ.

Дулааны эрчим хүчний орлого 463.1 сая төгрөгөөр давсан нь ЭХЗХ-ны 2019 оны 121 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг тогтоосон үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Үйл ажиллагааны бус орлого 516.6 сая төгрөгөөр тасарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг орлогын аргаар бүртгэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан 6 дугаар сард орлогод авснаас шалтгаалсан байна. Орлогын аргаар бүртгэсэн тул ашиг алдагдалд нөлөөлөхгүй.

Нийт 40,510.8 сая төгрөгийн зардлыг үндсэн болон үйл ажиллагааны бус орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 39,777.2 сая төгрөгийн зардал зарцуулж, 733.6 сая төгрөгийн зардал хэмнэсэн байна.

Станцын их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, өөрийн хөрөнгө оруулалтаар нийт 5,381.7 сая төгрөгийн 125 ажлаас 122 ажлыг 3,878.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 6.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 6.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Авто машиныг эд ангиар нь салгаж бүртгэдэг, дараа тайлангийн гүйцэтгэл зэрэг асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэтийн дулааны цахилаан станц ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 604 мэдээллийг хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 6.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 48.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. *Татвартай холбоотой асуудал*

3.1.1 **Илрүүлэлт:** Худалдан авалтын гэрээтэй 19 аж ахуйн нэгж байгууллагаас 74.2 сая төгрөгт ногдох 6.7 сая төгрөгийн татварыг тооцож тайлагнаагүй байна. Энэ нь НӨАТ-ийн тухай хуулийн 17.3.4 "албан татвар суутган төлөгч хоорондын бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг баталгаажуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын падааны бүртгэлийг холбогдох мэдээллийн санд оруулж, мэдээллийг 7 хоногт багтаан нэгдсэн системд илгээнэ" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.1.2 **Эрсдэл:** Холбогдох хууль хэрэгжихгүй байх, татвар дутуу тайлагнах

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Хуулийг хэрэгжүүлж, татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж ажиллах

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид НӨАТ төлөгч компаниас худалдан авах зарчмыг баримталж ажиллана.

3.2. *Татвартай холбоотой асуудал*

3.2.1 **Илрүүлэлт:** Худалдан авалтын гэрээг түүвэрлэн үзэхэд 5 аж ахуйн нэгжтэй сунгалтын гэрээ байгуулаагүй, хугацаа сунгах тухай гүйцэтгэгчээс ирүүлсэн албан бичигт цохолт хийсэн, чанарын баталгааг харилцан адилгүй суутгадаг зэрэг зөрчлүүд нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2.2 **Эрсдэл:** Холбогдох хууль хэрэгжихгүй байх, худалдан авах үйл ажиллагаа үнэн зөв байдал алдагдах

- 3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Сунгалтын гэрээ батлуулж, чанарын баталгааг хуулийн дагуу суутгаж ажиллах
- 3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** 2020 оны худалдан авах ажиллагаанд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.3 **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой**

3.3.1 **Илрүүлэлт:** Үйлдвэрлэлийн өртгийг тооцохдоо борлуулалт удирдлагын зардалтай холбоотой зардлыг өртөгт шингээн нэгжийн өртгийг өсгөж тооцож байхаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан нь СТОУС болон НББОУС 2 бараа материал хэсгийн 19-д "үйлчилгээний байгууллагын өртөгт борлуулалт болон ерөнхий удирдлагын ажилтанд хамаарах хөдөлмөрийн зардал ба бусад зардлыг өртөгт оруулахгүй харин тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.3.1 **Эрсдэл:** Санхүүгийн үйл ажиллагааны хяналт сулрах, холбогдох хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байх

3.3.3: **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллах

3.3.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Салбарын хэмжээнд өөрчлөгдсөн тохиолдолд дагаж мөрдөнө

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,112,212,503.87	767,220,334.10
1.1.2	Дансны авлага	2,426,707,358.80	3,318,306,053.06
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,629,937.69	5,613,109.83
1.1.6	Бараа материал	2,492,097,649.39	3,248,731,434.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	794,970,040.39	797,486,132.32
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,832,617,490.14	8,137,357,063.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	59,738,632,080.13	64,636,521,468.81
1.2.2	Биет бус хөрөнгө	20,955,499,894.09	20,992,277,674.76
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,694,131,974.22	85,628,799,143.57
1.3	Нийт хөрөнгийн дүн	87,526,749,464.36	93,766,156,206.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	123,283,060.64	221,524,127.16
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,583,476,274.56	6,979,546,804.47
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,884,955.66	2,150,582.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,713,644,290.86	7,203,221,514.03
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	40,217,483.23	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	40,217,483.23	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,753,861,774.09	7,203,221,514.03
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.1	-төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,734,205,000.00	20,734,205,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(13,543,825,000.63)	(12,753,777,998.05)
2.3.11	Эздийн өмчийн дүн	85,772,887,690.27	86,562,934,692.85
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	87,526,749,464.36	93,766,156,206.88

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	35,366,842,042.38	39,760,079,946.36
2	Борлуулалтын өртөг	31,741,035,862.41	34,987,956,324.18
3	Нийт ашиг (алдагдал)	3,625,806,179.97	4,772,123,622.18
4	Түрээсийн орлого	918,000.00	5,183,999.99
5	Хүүний орлого	147,494,342.37	34,653,886.56
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	354,822,746.02	923,131,511.49
9	Борлуулалт, маркетингийн зардал	28,389,643,974.12	3,640,850,393.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	701,160,401.56	974,160,243.91
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	190,074,563.31	167,137,943.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(7,150,866.64)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	398,862,329.39	945,793,573.03
19	Орлогын татварын зардал	54,966,917.39	104,162,258.65
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	343,895,412.00	841,631,314.38
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	343,895,412.00	841,631,314.38
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	343,895,412.00	841,631,314.38
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	19,447,456,792.53	34,360,784,468.64	-	(13,882,774,412.61)	39,925,466,848.56
2	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	34,360,784,468.64	-	(13,882,774,412.61)	39,925,466,848.56
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	343,895,411.98	343,895,411.98
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	20,734,205,000	-	20,734,205,000.00
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	(4,946,000.00)	(4,946,000.00)
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	24,774,266,429.73	-	-	24,774,266,429.73
8	2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000	(13,543,825,000.63)	85,772,887,690.27
2	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000	(13,543,825,000.63)	85,772,887,690.27
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	841,631,314.38	841,631,314.38
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	(51,584,311.80)	(51,584,311.80)
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000	(12,753,777,998.05)	86,562,934,692.85

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	33,410,459,324.24	38,201,333,520.54
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	33,253,002,999.01	38,066,219,389.80
1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	157,456,325.23	135,114,130.74
1.2	Мөнгөн зарлагын дүн	29,503,518,105.41	34,583,314,628.56
1.2.1	Ажиллагчдад төлсөн	6,924,539,806.79	8,338,623,854.19
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,176,533,450.45	2,777,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	12,099,025,965.62	13,708,854,473.05
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,581,257,733.03	1,874,052,279.42
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,684,492,153.42	5,334,073,630.54
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,992,065,265.99	2,487,105,366.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,768,611.00	9,199,065.05
1.2.9	Бусад мөнгөн зарлага	37,835,119.11	54,405,960.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,906,941,218.83	3,618,018,891.98
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	147,494,342.37	34,653,886.56
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	147,494,342.37	34,653,886.56
2.2	Мөнгөн зарлагын дүн	4,848,947,559.23	3,946,080,636.51
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,623,247,186.03	3,876,308,692.51
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	225,700,373.20	69,771,944.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,701,453,216.86)	(3,911,426,749.95)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	4,946,000.00	51,584,311.80
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	4,946,000.00	51,584,311.80
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,946,000.00	51,584,311.80
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(799,457,998.03)	(344,992,169.77)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,911,670,501.90	1,112,212,503.87
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,112,212,503.87	767,220,334.10

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.10	Аудитын нэр: ЭДЦС ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/47/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	НӨАТ-гүй худалдан авалт хийсэн	6.7	Зөвлөмж өгөх	Аудитор	Д.Заяажаргал
2	Худалдан авалтын гэрээг түүвэрлэн үзэхэд 5 аж ахуйн нэгжтэй сунгалтын гэрээ байгуулаагүй, хугацаа сунгах тухай гүйцэтгэгчээс ирүүлсэн албан бичигт цохолт хийсэн, чанарын баталгааг харилцан адилгүй суутгадаг зэрэг зөрчилүүд байна.		Зөвлөмж өгөх	Аудитор	Д.Заяажаргал
3	Үйлдвэрлэлийн өртгийг тооцохдоо борлуулалт удирдлагын зардалтай холбоотой зардлыг өртөгт шингээн нэгжийн өртгийг өсгөж тооцсон бөгөөд Түлш эрчим хүчний яамны хэмжээнд Бодлогын баримт бичигт ингэж тусгагдсан байна.		Зөвлөмж өгөх	Аудитор	Д.Заяажаргал
	Нийт	6.7			